



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 485

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нийт 20,788,580.00 (хорин сая долоон зуун наян найман мянга таван зуун наян) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Амаржаргал, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирал Б.Нарантуяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 11 дугаар сарын 19-ний өдрийн
485... дугаар тогтоолын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ДАНСНААС ХАСАХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Ä/ä	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тг ширхэг	Ашиглалтад орсон огноо	Балансын		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
					Нэг бүрийн үнэ	Нөөц /тг/		
1	Гүйлтийн зам /жижиг/	ш	1	2004/01/01	320,000.00	320,000.00	320,000.00	-
2	Гүйлтийн зам /том/	ш	1	2004/01/01	480,000.00	480,000.00	480,000.00	-
3	Тестен үнэлгээний машин	ш	1	2005/01/01	6,660,500.00	6,660,500.00	6,660,500.00	-
4	Рак /серверийн т/төхөөрөмж /	ш	1	2008/12/19	1,046,320.00	1,046,320.00	1,046,320.00	-
5	Сүлжээ салаалагч /сервер/	ш	1	2008/12/19	2,187,900.00	2,187,900.00	2,187,900.00	-
6	Айркондейшин	ш	1	2009/07/30	1,516,900.00	1,516,900.00	1,516,900.00	-
7	Ус цэвэршүүлэгч /CWP-2182/	ш	1	2009/09/18	470,010.00	470,010.00	470,010.00	-
8	Ус цэвэршүүлэгч /CWP-2182/	ш	2	2009/09/18	469,990.00	939,980.00	939,980.00	-
9	Аяга таваг угаагч	ш	1	2009/11/02	789,990.00	789,990.00	789,990.00	-
10	Факсийн аппарат /Panasonic/	ш	1	2011/01/27	206,980.00	206,980.00	206,980.00	-
12	Аяга хатаагч Ариутгагч	ш	1	2011/05/11	330,000.00	330,000.00	330,000.00	-
13	Мөрний машин /Фитнесс/	ш	1	2011/10/01	1,090,000.00	1,090,000.00	1,090,000.00	-
14	Суурин дугуй	ш	1	2011/10/01	950,000.00	950,000.00	950,000.00	-
15	Суурин олон функтэй машин /Фитнесс/	ш	1	2011/10/01	2,650,000.00	2,650,000.00	2,650,000.00	-
16	Эрвээхэй машин /Фитнесс/	ш	1	2011/10/01	1,150,000.00	1,150,000.00	1,150,000.00	-
НИЙТ ДҮН						20,788,580.00	20,788,580.00	-
						(хорин сая долоон зуун наян найман мянга таван зуун наян)		